

**“Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төсөл”- ийн  
хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны  
үр дүнд хийсэн хяналт-шинжилгээ үнэлгээний тайлан**

2008.04.09

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

“Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төсөл”-ийн хүрээнд 2007 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанд оруулан хэлэлцүүлж шийдвэр гаргуулах.

**Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн Газрын 2006 оны 3 дугаар сарын 22-ны өдрийн 51 дугаар тогтоолоор батлагдсан “*Яам, аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам*”-ыг арга зүйн үндэс болгов.

Төслийн нэгдсэн тайланг уншиж судалсны дараа Эрүүл мэндийн байгууллагууд, Үндэсний статистикийн газар болон бусад мэргэжлийн байгууллагуудаас гаргасан мэдээ, мэдээллийг судлан харьцуулан дүгнэх аргаар дүн шинжилгээ хийв.

Мөн Сэлэнгэ, Архангай, Булган, Төв аймгийн зарим сумдад томилолтоор ажиллан төслийг хэрэгжүүлж буй анхдагч нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсаны зэрэгцээ Ховд, Баянхонгор, Хэнтий, Өвөрхангай аймгийн нийт малын эмч нартай уулзаж санал солилцох, асууж магадлах, асуумжаар судалгаа авах арга хэлбэрүүдээр мэдээлэл цуглуулж дүн шинжилгээ хийсэн болно.

**Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, түүний үнэлгээ**

“Малын зарим архаг халдварт өвчинтэй тэмцэх төсөл”- ийг Засгийн газрын 2002 оны 233 дугаар тогтоолоор батлан гаргасан. Төслийн хэрэгжих хугацаа: 2003-2007 он.

**АДУУНЫ ХАЛДВАРТ ЦУС БАГАДАХ ӨВЧИН**

АХЦБӨ-тэй тэмцэх арга хэмжээг шат дараалан хэрэгжүүлсний үр дүнд 1958 онд 3.7 хувь хүртэл өссөн байсан халдварлалтыг 1987 онд 0.94 хувь хүртэл бууруулж чадсан байжээ. 1987 оноос хойш 12 жилийн хугацаанд шинжилгээ хийгээгүйгээс өвчний халдварлалт, тархалт, эрс нэмэгдсэн байна.

2000 оны зун, намрын улиралд Сант суманд 182, Түшиг суманд 187 бүгд 369 адуу өвчилж хорогдсон. Адууг орон нутгийн зах зээлийн ханшаар /65 мянган төгрөг/ тооцоход 55.5 сая төгрөгийн хохирол учруулсан байна. Эдгээр 2 сумын адууны 13.0 хувь нь энэ өвчнөөр хорогдсон байна.

Зөвхөн 2 сумын хэмжээнд авч үзэхэд ийм их хэмжээний хохирол учруулах хэмжээнд хүрсэн байсан тул АХЦБӨ-ний халдварлалтын хүрээг тогтоож, вирус тээгчийг илрүүлэн тэмцэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлага тулгарсан байна.

Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт					Хувь
Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Дархан-Уул, Орхон аймгуудын бүх адуун сүрэгт жил бүр ийлдэл судлалын аргаар шинжилгээ хийж өвчний халдварлалтын түвшинг тогтоох.	120300 адуу шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн.					<b>90.3</b>
		Сумын тоо	Шинжилгээнд хамрагдсан мал	Эерэг урвал үзүүлсэн	Халдварлалтын хувь	
	СЭ	17	39250	380	0.9%	
	БУ	6	20777	326	1.5%	
	ХӨ	7	32065	194	0.6%	
	ДА	3	8500	8	0.1	
	ОР	2	8000	0	0%	
Улс.дундаж		108592	908	0.83		
Шинжилгээгээр эерэг гарсан адууг тухай бүрд ялгаж мал эмнэлгийн хяналтын дор хэрэгцээлүүлэх замаар адуун сүргийг эрүүлжүүлэх.	2007 онд орон нутагт ажиллагсадын томилолт, шинжилгээнд хэрэглэх хуруу шил, зүү, зүү баригч, бусад үйл ажиллагааны зардлыг бүрэн олгосоноос гадна өвчтэй адууг хэрэгцээлэх үед олгох нөхөн төлбөрийг “Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах хууль”-д заасны дагуу олгосон тул төлөвлөсөн арга хэмжээг иж бүрэн цогцолбороор хэрэгжүүлж чадсан байна.					<b>100</b>
Шинжилгээгээр АХЦБӨ илрээгүй аймаг, сумдын аж ахуйн нэгж, айл өрхийн адуун сүрэг АХЦБӨ-өөс эрүүлжсэнийг баталгаажуулан гэрчилгээ олгоно.	Энэ ажил хийгдээгүй					<b>0</b>
АХЦБӨ-өөр өвчилсөн адууны судалгаа, мониторинг гаргах.	Эпизоотологийн судалгаа гарсан.					<b>100</b>
<b>1. 2007 оны гүйцэтгэлийн үнэлгээ:</b>						
$100 * 0.4 + 100 * 0.2 + 0 * 0.1 + 100 * 0.3 = 90.0\%$						
<b>2. Үр дүн, түүний тогтворжилтын үнэлгээ:</b> Төсөл хэрэгжих хугацаанд төлөвлөсөн ажлууд хугацаандаа зохион байгуулагдсан хэдий ч үр дүнгийн шалгуур үзүүлэлт болох халдварлалтын хувь өмнөх оныхоос 2 дахин нэмэгдсэн байна. Халдварлалтын хувийг аймгуудаар авч үзвэл ХӨ, ДА, ОР аймагт харьцангуй тогтвортой СЭ аймагт 2.3 дахин, БУ аймагт 3.3 дахин өсжээ. Иймээс хэрэгжүүлсэн ажлын үр дүн, түүний тогтворжилт <b>50,0%</b> -ийн үнэлгээтэй байна.						
<b>3. Үр нөлөөний үнэлгээ:</b> Энэ үзүүлэлтийг үнэлэхдээ төслийн үр дүнг хүртэгчид болох малчдын сэтгэхүйд ямар өөрчлөлт оруулсан бэ гэдгийг гол хэмжүүр болгосон байгаа. Энэ өвчнөөс учрах хор хохиролын талаар малчдыг мэдлэгтэй болгоход анхаарсан хэдий ч тэдэнд ноогдож буй үүрэг хариуцлагыг нь ухамсарлуулах талаар орон нутгийн МЭ-ийн байгууллага мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран ажиллах тал дээр хангалтгүй ажилласан байна. Жишээ нь: Өвчтэй мал илэрсэн өрх малаа нядлаагүй байхад мэргэжлийн хяналтын байцаагч тэр малчинд шаардлага тавиагүй атлаа малын эмчийг торгож шийтгэсэн тохиолдол гарч байсан байна. Энэ бол тэдний хамтын ажиллагааны дутагдалтай талын бодит жишээ. Төслийн энэ зорилтын үр нөлөөний үнэлгээ <b>70.0%</b> байна.						
<b>Энэ зорилтын дундаж үнэлгээ <math>(90.0 + 50.0 + 70.0)/3 = 70.0\%</math> байна.</b>						

## АДУУНЫ ЯМ ӨВЧИН

Ям өвчинтэй тэмцэх олон улсын төлөвлөгөөт арга хэмжээг 1965 оноос эхлэн хэрэгжүүлсний дүнд 6.9%-д хүрсэн байсан халдварлалт жил дараалан буурч сүргийн эрүүлжилт сайжирч байсан боловч, 1990 оноос хойш ямын шинжилгээг хийлгүй орхигдуулснаас тархалт, халдварлалт ямар хэмжээнд байгаа нь тодорхойгүй болсон.


1997-2000 оны хооронд зөвхөн судалгаа шинжилгээний хүрээнд Төв, Улаанбаатар, Архангай, Дорнод, Хэнтий аймгуудын нийт 477 адуунд ямлуураар түүвэр шинжилгээ

хийхэд 5 адуу эерэг, 11 адуу сэжигтэй дүн үзүүлсэн. 2002 оны 6 дугаар сард Дархан-Уул аймгийн Шүүхийн шийдвэр биелүүлэх албаны туслах аж ахуйн 90 адуунд ямлуурын сорил тавихад 4.4 хувь нь өвчтэй байв.

Иймээс халдварлалтын түвшинг тогтоох, өвчтэй адууг илрүүлэн нядлах замаар сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээг эрчимтэй хэрэгжүүлэх шаардлага тулгарсан.

Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
Бүх аймгуудын адуун сүргийн гурваас дээш насны адууны 20 хувьд нь ямлуурын 2 удаагийн сорилыг зохих зааврын дагуу тавьж шинжлэх, ямын голомт, халдварлалтын түвшинг тогтоох.	Тандалт шинжилгээнд 93500 адуу хамруулахаас 86832 адууг хамруулан шинжлэхэд Булган аймагт 4, Сүхбаатар аймагт 26 нийт 30 адуунд ям өвчин оношлогдож халдварлалт улсын хэмжээнд 0.035%-тай байна.	92.9
Шинжилгээгээр эерэг гарсан адууг тухай бүрд нь ялгаж мал эмнэлгийн хяналтын дор нядлах замаар адуун сүргийг эрүүлжүүлэх.	Өвчин оношлогдсон адууг мал эмнэлгийн байгууллагын хяналтанн дор нядлуулан устгах арга хэмжээг зохион байгуулсан.	100
Шинжилгээгээр ям өвчин илрээгүй аймаг, сумын аж ахуйн нэгж, айл өрхийн адуун сүрэг ям өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулан гэрчилгээ олгоно.	Энэ ажил хийгдээгүй	0
<b>1. 2007 оны гүйцэтгэлийн үнэлгээ:</b>		
$92,9 * 0.5 + 100 * 0.3 + 0 * 0.2 = 76.4$		
<b>2. Үр дүн, түүний тогтворжилтын үнэлгээ:</b> Төслийн хугацаанд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажлыг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэсэний үр дүнд адууны ям өвчний халдварлалтын хувь 0.4 %-аас аажмаар буурсаар 0.035 % хүрчээ. Иймээс хэрэгжүүлсэн ажлыг хангалттай үр дүнд хүрсэн гэж дүгнэж байна. Сүүлийн жилүүдийн халдварлалтын хувийг харьцуулж үзэхэд хүрсэн үр дүн тогтвортой хадгалагдаж байгаа нь харагдаж байгаа тул <b>100,0%</b> -ийн үнэлгээ өгөх боломжтой юм.		
<b>3. Үр нөлөөний үнэлгээ:</b> Адууны ям өвчний тархалт, халдварлалтыг эрс бууруулж чадсан нь малчдад энэ өвчний улмаас үүсэх хор хохиролын талаар мэдлэг олгож, тэдний үүрэг, оролцоог ойлгуулж чадсантай тодорхой хэмжээгээр холбоотой гэж үзэн <b>100.0</b> –ийн үнэлгээ өглөө.		
<b>Энэ зорилтын дундаж үнэлгээ <math>(76,4 + 100.0 + 100.0)/3 = 92,1%</math> байна.</b>		

#### Адууны ям өвчний халдварлалтын түвшин \хувиар\



#### ҮХРИЙН ЛЕЙКОЗ ӨВЧИН

Манай улсад үхрийн лейкоз өвчин анх 1982 онд оношлогдсон. 1999-2001 онуудад Төв аймаг, Улаанбаатар хотын 10.000 гаруй үхрийг хамруулан шинжлэхэд Төв аймгийн Баянчандмань дахь “Морьт” ХХК-ийн Оросын “хар тарлан” үхрийн 38 хувь, Борнуур сумын Өнжин, Даваабулаг дахь “Германы хар тарлан” үхрийн 54 хувь, Сэлэнгэ

аймгийн Зүүнхараа сумын “Талын улаан” үхэр 13 хувь, Улаанбаатар хотын Партизаны “Оросын хар тарлан” үхэр 81 хувь нь эерэг урвалтай гарсан байна.

Төрөл бүрийн үүлдрийн үхрийн лейкоз өвчний халдварлалт жилээс жилд нэмэгдэх хандлагатай байгаагийн дээр эрлийз үхэрт уг өвчин оношлогдож эхэлсэн байна. Тухайлбал, Төв аймгийн Нөхөрлөлийн сангийн аж ахуйн “Оросын хар тарлан” үүлдрийн үхэрт 1984 онд лейкоз илрүүлэх шинжилгээ хийхэд 15.1%-ийн халдварлалттай байсан бол 1994 онд шинжлэхэд 46.5% болж өссөн байна. Мөн Батсүмбэр дэх Баянтолгойн “Алатау” үүлдрийн үхэрт 1984 онд шинжилгээ хийхэд эрүүл байсан бол 1993 онд 33%-ийн халдварлалттай болсон байжээ.

Иймээс энэ өвчинтэй тэмцэх арга хэмжээг эрчимжүүлэх шаардлага тулгарч энэхүү төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын нэгэн зорилт болгон оруулсан байна.

Үхрийн лейкоз өвчний шинжилгээнд 2003 оноос Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Малын халдварт өвчний лабораторид үйлдвэрлэсэн НТУ-ын антиген, хяналтын эерэг, сөрөг ийлдэсийг хэрэглэж байгаа бөгөөд шинжилгээг Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэн хариуцан гүйцэтгэж байна. Шинжилгээнд лейкоз өвчний голомт бүхий Дархан–Уул, Сэлэнгэ, Төв аймаг, Улаанбаатар хот орчмын арвин ашиг шимт үүлдрийн үхрийг хамруулдаг.

Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
Үхрийн лейкозоор тайван бус бүс нутагт маллагдаж буй арвин ашиг шимт үүлдрийн үхрийн цусыг жилд 3 удаа авч шинжлэх.	Нийт 6900 үхэр шинжлэхээр төлөвлөснөөс 6727 үхэр шинжилгээнд хамрагдсан байна.	97,5
Тугалыг 6 сартайгаас нь эхлэн улирал бүр шинжилж эрүүл гунжийг хээлтүүлэгт оруулан, 7 сарын хээлтэйд нь дахин шинжлэх замаар эрүүлжүүлэх.		100
Шинжилгээгээр эерэг гарсан үхрийг ялган, таних тэмдэг хийж, аажмаар хэрэгцээлнэ.	Энэ онд өвчтэй мал илрээгүй болно.	-
Өндөр халдварлалттай нь тогтоогдсон хот айл, фермийн мал дахь халдварлалтын түвшинг 0.1-1.0% хүртэл бууруулна.	2006 онд 0.49%-ийн халдварлалттай байсан ба 2007 онд оношлогдоогүй тул энэ шалгуур үзүүлэлт бүрэн биелэсэн байна.	100
<b>1. 2007 оны гүйцэтгэлийн үнэлгээ:</b>		
<b><math>97.5 * 0.4 + 100.0 * 0.4 + 100.0 * 0.2 = 99.0\%</math></b>		
<b>2. Үр дүн, түүний тогтворжилтын үнэлгээ:</b> Сүүлийн жилүүдэд лейкоз өвчний халдварлалтын хувь аажмаар буурч 2007 онд уг өвчин оношлогдоогүй байгаа тул <b>100,0%</b> -ийн үнэлгээ өгч байна.		
<b>3. Үр нөлөөний үнэлгээ:</b> Маш өндөр халдварлалттай байсан лейкоз өвчний тархалт, халдварлалтыг эрс бууруулж чадсан нь малчдад энэ өвчний улмаас үүсэх хор хохиролыг бүрэн ойлгуулж идэвхтэй хамтран ажиллаж чадсаны үр дүн гэж үзэн <b>100.0</b> –ийн үнэлгээ өгөхөөр шийдвэрлэв.		
<b>Энэ зорилтын дундаж үнэлгээ <math>(99.0 + 100.0 + 100.0)/3 = 99,7\%</math> байна.</b>		

## ҮХРИЙН СҮРЬЕЭ ӨВЧИН

1966-1970 онуудад үхэр сүрэгт сүрьеэгийн шинжилгээг хийхэд халдварлалт 10.2 % -тай байжээ. Сүрьеэтэй тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлснээр халдварлалтын хувийг 1970 онд 0.01% хүртэл бууруулж чадсан байна.

Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгээс 1997-1998 онуудад Амгалан дахь хорих ангийн үхрийг шинжилгээнд хамруулахад 8.1%, Хэнтий аймгийн Батширээтэд 1.5%, Дадал суманд 0.8% нь тус тус сүрьеэ өвчний халдварлалттай байгаа нь тогтоогдсон. 1997-2001 онд 4 аймгийн 6 сум, 1 туслах аж ахуйн 2901 үхэрт сүрьеэ

өвчний шинжилгээг хийхэд 37 үхэр эерэг урвалтай гарч халдварлалтын хувь 1.2%-тай байв.

Түүвэр шинжилгээгээр халдварлалтын хувь өндөр байгаа нь нэгэнт тогтоогдсон тул халдварлалтын түвшин, тархалтын хязгаарыг нарийвчлан тогтоож өвчтэйг ялган нядлах замаар өвчний халдварлалтыг багасгах улмаар эрүүлжүүлэх шаардлагатай болсон байна.

Хэрэгжүүлэх ажил	Хэрэгжилт	Хувь
Голомттой аймагт хийх эрүүлжүүлэх шинжилгээг 2003-2005, 2006-2007 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	Энэ ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан.	100
Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа бүх үхрийн 10 хувьд сүрьеэлүүрийн арьсны харшил сорил, нэвчин тунадасжих урвалын шинжилгээг тухайн аймаг, сумдын мал эмнэлгийн алба гардан гүйцэтгэнэ.	Сүрьеэ өвчний халдварлалтын түвшин тогтоох тандалт шинжилгээнд 21 аймгийн 67,6 мянган үхэр хамруулахаар төлөвлөснөөс 71.6 мянган үхэр хамрагдаж Сүхбаатар аймагт 12 үхэр эерэг урвал үзүүлж халдварлалт улсын дунджаар 0.02% байна	105.9
Шинжилгээгээр эерэг гарсан үхрийг тухай бүрд нь сүргээс ялган тусгаарлаж, мал эмнэлгийн хяналтын дор нядлах замаар үхэр сүргийг эрүүлжүүлнэ.	Өвчин оношлогдсон үхрийг мал эмнэлгийн байгууллагын хяналтанн дор нядлуулан усгах арга хэмжээг зохион байгуулсан.	100
Шинжилгээгээр сүрьеэ өвчин илрээгүй аймаг, сумын аж ахуйн нэгж, айл өрхийн үхэр сүрэг сүрьеэ өвчнөөс эрүүлжсэнийг баталгаажуулан гэрчилгээ олгоно.	Энэ ажил хийгдээгүй	0
<b>1. 2007 оны гүйцэтгэлийн үнэлгээ:</b> $100 * 0.3 + 105.9 * 0.3 + 100 * 0.2 + 0 * 0.2 = 81,8\%$		
<b>2. Үр дүн, түүний тогтворжилтын үнэлгээ:</b> Төсөл батлагдахаас өмнө 2000 онд шинжилгээнд хамрагдалт 49.2%, халдварлалт 1.0%, 2001 онд шинжилгээнд хамрагдалт 80.9%, халдварлалт 0.04%, 2002 онд шинжилгээнд хамрагдалт 82.7%, халдварлалт 0.4% байжээ. 2004-2006 онд халдварлалт багасан тэр хэмжээндээ хадгалагдаж байсан боловч 2007 онд бага зэрэг нэмэгдсэн байна. Иймээс үр дүнгийн тогтворжилт <b>70.0</b> % байна гэж дүгнэлээ.		
<b>3. Үр нөлөөний үнэлгээ:</b> Төслийн үр шимийг хүртэгчдэд хүрч буй үр нөлөөг хангалттай гэж үзэн <b>100.0</b> –ийн үнэлгээ өгч байна.		
<b>Энэ зорилтын дундаж үнэлгээ <math>(81.8 + 70.0 + 100.0)/3 = 83.9\%</math> байна.</b>		

### Үхрийн сүрьеэ өвчин

2003 он	2004 он	2005 он	2006 он	2007 он
<b>Шинжилгээнд хамрагдсан үхрийн тоо /мян.толгой/</b>				
158,2	116,62	113,2	88,0	71,6
<b>Үхрийн сүрьеэ өвчний халдварлалтын түвшин /хувь/</b>				
0,03	0,01	0,01	0	00,2

### Дөрөв. Ерөнхий үнэлгээ

	Адууны халдварт цус багадаа өвчин	Адууны ям өвчин	Үхрийн лейкоз өвчин	Үхрийн сүрьеэ өвчин	Дундаж үнэлгээ
<b>Хувь</b>	<b>70.0</b>	<b>92.1</b>	<b>99.7</b>	<b>83.9</b>	<b>86,4</b>
<b>Оноо</b>	<b>3.50</b>	<b>4.61</b>	<b>4.98</b>	<b>4,19</b>	<b>4.32</b>

Төслийн хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг жигд ханган биелүүлэх асуудалд хангалтгүй анхаарч ажилласан байна. Гэсэн хэдий ч ихэнх шалгуур үзүүлэлтүүдийг

төлөвлөсөн хэмжээнд хүргэж биелүүлсэн тул “Хангалтай” үнэлгээтэй хэрэгжсэн гэж дүгнэж байна.

#### **Тав. Дүгнэлт**

- ◆ 2007 онд батлагдсан төсвийн хүрээнд төлөвлөгдсөн ажлуудыг 76.4-99.0 хувийн гүйцэтгэлтэй биелүүлсэн байна.
- ◆ Өвчтэй малыг нядлан устгах замаар сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээнд зориулсан нөхөн олговорын асуудал энэ оноос эхлэн шийдвэрлэгдсэн нь ажлын эцсийн үр дүнг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой шийдвэр болжээ.
- ◆ Адууны ям, үхрийн лейкоз өвчний халдварлалтын хувь буурч тэр түвшиндээ тогтвортой хадгалагдаж байна. Харин адууны халдварт цус багадах өвчний халдварлалтын хувь өссөн байгаа нь өмнөх жилүүдэд буурч байсан үр дүн цаашид тогтвортой хадгалагдаж чадахааргүй байна гэсэн дүгнэлтэнд хүргэлээ.
- ◆ Мал сүргээ тухайн халдварт өвчнөөс эрүүлжүүлсэн сум орон нутагт гэрчилгээ олгох ажлыг огт зохион байгуулаагүй байна.

#### **Зургаа. Санал, зөвлөмж**

- Төслийн үйл ажиллагааны үр дүнд хүрсэн түвшинг тогтвортой хадгалах асуудалд анхаарлаа хандуулж дараагийн жилийн үйл ажиллагаандаа тусгаж ажиллах шаардлагатай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭГ ХИЙСЭН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын мэргэжилтэн:

С.Дивангар

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

ХХААЯ-ны МХШҮГ-ын дарга:

Д.Бат-Эрдэнэ